



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/742

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Эрдэнийн шим” ХХК-ний барьж гүйцэтгэсэн иргэн Б.Даваадоржийн “Худалдаа, нийтийн үйлчилгээ”-ний барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	З.Өмиртай	- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Нямтулга	- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
	О.Дарьжав	- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрүүл хуй халдвар хамгаалалын хяналтын улсын байцаагч
	М.Нансалмаа	- Нийтийн аж ахуйн “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
	Н.Ням-Эрдэнэ	- “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер
	Ш.Мөнгөнчимэг	- Зураг төслийн “Дээрэнбуйлдинг” ХХК-ний захирал
	Б.Амарболд	- Гүйцэтгэгч “Эрдэнийн шим” ХХК-ний захирал
	Б.Даваадорж	- Захиалагчийн төлөөлөгч

Нарийн бичгийн дарга:

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Худалдаа, нийтийн үйлчилгээний барилга угсралтын ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга /З.Өмиртай/ -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т. ЖАРГАЛСАЙХАН